

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2014 ОНЫ 17 ДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2014 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 14 цаг 05 минутад эхэлж, 15 цаг 32 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 27 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Хяналт үнэлгээ, шинжилгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргуулах тухай	<p>Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Дэрэмийн Эрдэнэсүвдыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх.</p> <p>2.Энэ тогтоолын 1 дэх хэсэгт нэр заасан иргэн Дэрэмийн Эрдэнэсүвдыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Отгонжаргалд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	Орхон, Булган аймагт зохион байгуулсан нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн</p>

	<p>дүнгийн тухай</p>	<p>шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2014 оны 05 дугаар сарын 08-10-ны өдрүүдэд Булган аймаг, Орхон аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 05 дугаар сарын 22 -ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. Булган аймаг, Орхон аймагт 2014 оны 05 дугаар сарын 08- 10-ны өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1, 2, 3, 4 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий нийт 87 иргэнээс 53 иргэн /Булган аймагт 39, Орхон аймагт 14/-ийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 34 иргэн /Булган аймагт 21, Орхон аймагт 13/-ийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 5, 6, 7, 8 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 21 иргэн /Булган аймагт 15, Орхон аймагт 6/-ийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 14 иргэн /Булган аймагт 13, Орхон аймагт 1/-ийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх.</p> <p>3. Энэхүү тогтоолын 5-8 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 35 нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар</p>
--	----------------------	--

		<p>зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь салбар зөвлөл /Л.Батболд/-д, Орхон аймаг дахь салбар зөвлөл /В.Сумъяасүх/-д тус тус үүрэг болгох.</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Бусад асуудал: /Зарим яам агентлагт ажилласан ажлын хэсгийн тайлан сонсох/</p>	<p>Төрийн албаны зөвлөлийн даргын 2014 оны 04 дүгээр сарын 18-өдөр баталсан удирдамжийн хүрээнд яам, агентлагийн дэргэдэх салбар зөвлөлийн үйл ажиллагаатай танилцаж, заавар, зөвлөмж өгөх ажлыг зохих ёсоор гүйцэтгэсний дагуу</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн яам, агентлагийн дэргэдэх салбар зөвлөлүүдийн зөрчил, дутагдлыг арилгах талаар тодорхой санал, зөвлөмж хүргүүлэх, хэрэгжилтийг 2014 оны 08 дугаар сарын 30-ны дотор Төрийн албаны зөвлөлд ирүүлэхийг Салбар зөвлөлүүдэд үүрэг болгож, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллах</p> <p>2. Батлагдсан удирдамжийн дагуу бусад яам, агентлагуудын дэргэдэх салбар зөвлөлийн үйл ажиллагаатай танилцаж, арга зүйн зөвлөмж өгөх ажлыг 2 дугаар улиралд багтаан гүйцэтгэх чиглэлийг Ажлын албанд өгөв.</p>

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

